

Монгол хэлний “тос” хэмээх үгийн
эсрэгцэх харьцааг судлах тухай асуудалд

Жанцангийн БАТ-ИРЭЭДҮЙ*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Хэл шинжлэлийн салбар

ЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх ухааны сургууль

Received: 28 August 2025 / Accepted: 12 September 2025 / Published: 30 December 2025

Хураангуй: Монгол хэл бол олон зуун жилээр мал маллаж, амьдралын баян туршилага цуглуулж, түүнийгээ хэл, соёлдоо баттай дархлан шингээж үлдээж чадсан нүүдэлчдийн хэл бөгөөд энэ нь нүүдэлчдийн хэлний гол цөм үндсийг бүрдүүлж байдаг билээ. Нэг сэдэвт судалгааны ажлын хүрээнд монгол хэлний эсрэгцэх харьцаа, түүний дотор хэвсгэл хэллэг, сүгээр нэгжийн эсрэгцэх харьцааг тусгайлан судалж эрдэм шинжилгээний өгүүлүүд бичиж байгаа бөгөөд энэ удаагийн өгүүлэлд монгол хэлний ‘тос’ хэмээх үг, түүний хэлэхүйн эсрэгцэх харьцаа заах хэв шинжийг монгол хэлний зүйр цэцэн үг хэллэгийн жишээгээр хэл соёл, танин мэдэхүй, танихуйн үүднээс товч тайлбарлахыг хичээв. Эдгээр монгол хэлний сүгээр нэгж нь үгийн сангийн утгаар эсрэгцэхээс гадна тухайн хэлний соёл, танин мэдэхүйтэй холбогдон, бусад улс үндэстний сэтгэлгээнээс онцлог ялгаатай болохыг монгол хэлний баримтаар үзүүлэхийг оролдов.

Түлхүүр үгс: Сүгээр нэгж, хэвсгэл хэлц, тогтвортой хэллэг, эсрэг утгат үг, хэллэг, эсрэгцэл, эсрэг утгат харьцаа, эсрэг утгат хэв шинж, хос ёсны онол, тос, ус, тоос, торго, цус, сүү гэх мэт.

Antonymic Definition Study of Word "Tos" (Oil) in Mongolian

BAT-IREEDUI Jantsan

Department of Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

GE LI

School of Arts and Sciences, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia

* © Author(s), 2025, Email: batireedui@mas.ac.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Abstract: The Mongolian word "moc" means oil, a substance culturally and practically important in Mongolian life—from food to ritual. This study explores its antonymic or contrastive relationships with seemingly unrelated nouns: *yc* (water), *mooc* (dust), *mopzo* (silk), and *уyc* (blood), each representing a different element or metaphorical field. While "moc" doesn't have direct antonyms in the strictest lexical sense, it stands in semantic and metaphorical opposition to several Mongolian words based on texture, purity, ritual function, and symbolic value. These antonymic relationships deepen our understanding of how Mongolian categorizes and contrasts key substances in both everyday life and cosmology.

Key words: Sayings, Proverb, Fixed Expressions, Antonymic Word and Phrases, Antonymic Relation, Binary, Oil, Water, Dust, Silk, Blood and Milk etc.

1. Удиртгал

Энэ өгүүлэлд бид монголчуудын аж ахуй, ахуй соёл, аж төрөх ёс, амьжиргаа хоол унд, нүүдэлчдийн сэтгэлгээтэй холбоо бүхий ‘тос’ гэдэг үг, түүний сүегэр хэллэгийн хүрэн дэх эсрэгцэх харьцааг судлахаар сонгож авлаа. Тос бол монголчуудын хувьд малын гаралтай бүтээгдэхүүн бөгөөд хамгийн охь шимтэй, тэжээлийн чанартай, хүн, малын эрүүл мэндэд чухлаар нөлөөлдөг зүйл, нөгөө талаас соёлын болон бэлгэдлийн чухал чанартай зүйл гэж үзэж болно. Энэхүү үгийг монгол хэлний үгийн санд түгээмэл бөгөөд өргөн хэрэглэдэг, эрхэмлэн үздэг, аливаа сайн сайхан зүйлээ тостой холбон зүйрлэдэг нь монгол хэлээр сэтгэгчдийн нэг онцлог юм.

Аливаа хэл, соёлын харилцан хамаарлыг судлахад харьцуулах ба эсрэгцүүлэх арга түгээмэл байдаг. Ерөөсөө аливаа зүйлийн мөн чанарыг илрүүлэхэд өгүүлэгчийн үнэлэмж хамгийн чухал болохыг эрдэмтэд дурдсаар ирсэн. Учир нь ихэнх тохиолдолд алив нэгэн зүйлийг хооронд нь эсрэгцүүлсний үндсэн дээр сайн, муу үнэлэмжийг бий болгож, юмсыг ялгаруулж байдаг байна. Тиймээс сайн муу, сайхан муухай, зөв буруу, дээр доор гэж эсрэгцүүлэн айчлах нь хэлний нэгэн гол харьцаа болох юм.

2. Судалгааны арга зүй

Бид энэ өгүүлэлдээ Жэйкобсоны хос ёсны сургаал буюу бинарын гэх эсрэг тэсрэг байдлын онолыг Лакоффын зүйрлэлийн тухай үзэл баримтлалын онолтой хослуулан зүйр цэцэн үг дэх антоним харьцааг морфологийн бүтцийн диалектик сэтгэлгээний загвараар ертөнцийг хүлээн авах байдал, тухайн ард түмний сэтгэх үндэсний сэтгэлгээ, танин мэдэхүйн сэтгэл зүйг харьцуулан үзэх замаар асуудлыг авч үзэх юм. Зүйр цэцэн үгийн доторх эсрэгцэх харьцаа бол ертөнц дэх аливаа юмны нийтлэг зөрчил, эсвэл онцгой зөрчилт байдлыг илэрхийлэх гол баримт болж байдаг юм.

Цуглуулсан хэлний жишээ баримтуудыг ажиглан үзвэл ийнхүү аливааг эсрэгцүүлэх нь тун нийтлэг, магадгүй илүү олон хувийг эзлэх юм шиг ажиглагдаж байна. Харин энэ нь хэлэн дэх үгийн сангийн эсрэг утгатай үгийн тухай хэлэлцэнэ гэсэн үг биш. Өөрөөр хэлбэл эсрэг утгатай үг гэхээсээ илүү эсрэгцэх харьцааны тухай судалгаа гэсэн үг юм.

3. Өгүүлэгчийн үнэлэмжийн тухай

Өгүүлэгчийн үнэлэмжийн тухай доктор Ж.Баянсан “Нөгөөтээгүүр харилцаж байгаа хүн хийгээд өгүүлж байгаа юмандаа яаж хандаж байгаа харьцаа хандлага буюу өгүүлэгчийн үнэлэмж зүйрлэлд маш тодорхой илэрсэн байдаг. Ийм үнэлэмж нь сайн муу, сайхан муухай, таатай таагүй, зохистой зохисгүй гэх мэтээр юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар зэргийг эерэг, сөргөөр нь эсрэгцүүлэн айчилсан байдаг. Эдгээр нь тус бүрдээ мөн эсрэгцсэн олон дэд ай бүхий үнэлэмжийн тогтолцоо болно. Энэ нь ертөнцийн юм үзэгдэл, хүний амьдралын хэрэг

явдал маш олон талтай агаад хүн ч түүнийг янз бүрийн хэрэгцээний үүднээс олон өнцгөөс нь харах бололцоотой байдагтай холбоотой юм” (2016: 101) гэжээ. Түүний нэг нь бидний сонирхон сонгож авсан сэдэв болой.

Алив ард түмний эрхэлж буй аж ахуй, оршин буй ахуй соёл, ертөнцийг таньж мэдсэн мэдлэг, туршлага, юм үзэгдэл, шинж чанарын тухай ойлголтын талаарх сэтгэлгээний тогтсон хэв маяг нь өөр өөр байдаг нь ойлгомжтой. Энэ нь монгол хэлний хувьд ч сонирхолтой бөгөөд эсрэг утгатай үг болон хэлц үгийн сан хөмрөг, толь бичиг хийх явцад ажиглагдаж байсан төдийгүй энэ тухай лавлагааны толь бичгүүдэд (Бат-Ирээдүй нар, 2007: 269) нэгэнтээ хэвлэгдсэн байна. Зарим эрдэмтэн үгийн сангийн эсрэг утгатай үг хэллэг бол үндэсний шинжтэй гэж үздэг болохыг ч бид цаашдын судалгаандаа анхаарч үзэх тал бий.

Нүүдэлчин монголчуудын хувьд мал аж ахуй эрхлэн амьдардаг бөгөөд тэдний амьжиргааны нэг үнэлэмж нь өөх тос юм. Энэ бол хамгийн түрүүнд малын тарга хүч юм. Тарга хүч авсан мал жилийн хатуу хөтүү улирлыг ажралгүй давж, онд мэнд сайн орж, тэр хэрээрээ нүүдэлчдийн амьжиргаанд дам дамаа маш эерэг сайнаар нөлөөлж байдаг. Тийм учраас аливаа сайн сайхан зүйлийг тосоор төлөөлүүлэн жишиг болгож, харин муу муухай барагтай зүйлийн жишиг хэмжүүр нь тостой эсрэгцэх, тосны эсрэг зүйлүүд болж байдаг нь монгол ардын зүйр цэцэн үгээс тодорхой харагддагийг ажиглаад, энэхүү өгүүллийг бичих санаа төрсөн хэрэг. Яагаад гэвэл ‘тос’ хэмээх үг орсон зүйр цэцэн үг зэрэг тогтвортой хэллэг нь үндэсний сэтгэлгээний онцлог, хэв загвар зэргийг үзүүлэх гол хэрэглүүр болж байдаг ажээ.

Ер нь хэлний аливаа зүйр цэцэн үг, адилтгал зүйрлэл зэрэг тогтвортой хэллэг нь тэр чигтээ эсрэгцлийн үндсэн дээр бий болсон, эсрэг тэсрэг туйлын хязгаар орон зайд бий болсон ойлголт, үйл явдал болохыг монгол хэлний баримтаас ч элбэг ажиглаж болохыг өмнө дурдсан билээ.

‘Тос’ хэмээх үг нь дээр хэлсэнчлэн нүүдэлчдийн сэтгэлгээтэй холбоотой ойлголт учраас доктор Ж.Баянсангийн бичсэнээр “Нүүдэлчдийн сэтгэлгээг судлахдаа хүн – байгаль, хүн – мал, хүн – хүнтэй харьцах, харилцах онцлог гэсэн гурван үндсэн айг юуны урьд баримжаа болгож үзэх нь зүйтэй байна. Ийм харилцааны явцад үндэстний өвөрмөц ухамсар, сэтгэлгээний тогтвортой хэв маяг бий болдог байна” (2165 178).

Тийм учраас тос гэдэг зүйл монгол хүний хувьд яагаад чухал бөгөөд яагаад эерэгээр авч үздэг вэ, тосыг юутай эсрэгцүүлэн үздэг вэ гэдгийг хэлний баримтаар буюу тогтвортой хэллэг, зүйр цэцэн үгээс хайж үзэх нь монголчуудын эсрэгцүүлэх үнэлэмжийг тодорхой болгоход оновчтой хэрэг байж болох юм.

Монгол хэлний ‘тос’ хэмээх үгийн өнгөн ба гүн бүтцийн утгыг монгол үндэстний сэтгэлгээний орон зай (mental spaces)-н талаас сонирхон судалсан судлаачид бий. Тухайлбал, доктор Г.Гэрэлмаа, “Зарим монгол хэвшмэл хэлц үгийг бүтээж буй өгүүлбэрүүдийг салган авч үзвэл тус тусдаа шууд ба шууд бус нэрлэлтийн нэгж болж өнгөн ба гүн бүтцийн асуудал яригдах боловч үндэсний өвөрмөц сэтгэлгээгээр нэгдэн нийлж, өнгөн бүтцээс өнгөн бүтэц үүсэж, хэлний тогтвортой нэгж буй болж, улмаар гуравдагч соёлын утгыг агуулсан сүегэр нэгж болдог онцлогтой байна. Тухайлбал, “аргалын тус илч, ажлын тус тос” гэсэн зүйр үгийн утгыг тайлбарлахад эхний өгүүлбэрийн утгыг өнгөн бүтцийн талаас, харин сүүлийн “ажлын тус тос” гэсэн өгүүлбэрийг гүн бүтцийн талаас авч үзэж болно. Учир нь ‘тос’ гэдэг үг нь монголчуудын сэтгэлгээнд ашиг тустай, үр өгөөжтэй, чухал хэрэгтэй зүйлийн жишиг хэмжүүр (эталон) болно” (2019: 95-98) гэжээ.

“Аливаа хэлний мэдээллийг үүсгэх, хүлээн авч ойлгоход зөвхөн хэлний үгийн сангийн мэдлэг, хэлзүйн дүрмийн мэдлэг хангалттай биш, бас юм үзэгдэл, тэдгээрийн хоорондын харьцаа хамаарлын тухай ‘дэвсгэр мэдлэг’ (фоновые знание / энциклопедические знания) зайлшгүй шаардлагатай болно” (Баянсан, 2016: 15) гэж үздэг. Тийм учраас бид тос гэдэг үгтэй нэг зиндаанд үзэж байгаа юм уу, эсвэл эсрэгцүүлэн авч үзэж байгаа үг, хэллэг, түүний дэвсгэр мэдлэгийг анхааран үзэж, энэхүү ‘тос’ хэмээх үг болон бусад эсрэгцүүлэн үзэх хэмжүүр болгож буй үгийн утга чанарын талаар тус тус авч үзэв.

4. ‘Тос’ хэмээх үгийн эсрэгцэх харьцаа

Монголчуудын хувьд сайн, сайхан, нүнжигтэй, баян, хөрөнгөтэй, дор хаяж хоногийн хоолтой явахын жишиг хэмжүүр нь тос өөх боловч ‘өөх’-нөөс илүү ‘тос’ гэх үгийг илүү өргөн хэрэглэж иржээ. Тийм учраас монгол хүн

“Ажлын сайнаар ам тостой.”,

“Ажлын тус тос.”,

“Ажил хийсэн нь амандаа тостой.”,

“Сайн санаатны үг нь тос.”,

“Сайныг шахвал тос гарна.” гэх мэтээр хэлэлцдэг бөгөөд үүнийг хувь хүний ам хамар тостой байх тухай хэрэг биш наанадаж хоолтой ундтай, цаанадаж ажилтай амьдралтай, сайн сайхан байх гэсэн өргөн утга илэрхийлдэг болохыг бүх монгол сэтгэлгээтнүүд ойлгож байдаг. Харин ‘өөх’ гэдэг үгийг огт хэрэглээгүй байна.

Юуны өмнө дээр дурдсанчлан ‘тос’ гэдэг үг нь дангаараа эерэг, сайн сайхны утга илэрхийлэх дам утга илтгэдэг тул энэ үг оролцсон олон зүйр цэцэн үгийг бид монгол хэлний жишээ баримтаас олж болно. Тухайлбал,

Ажлын сайнаар ам тостой.

Аргалын тус илч, ажлын тус тос.

тос даасан намар,

тосон үг,

тосон өнгө,

шар тос шиг,

тосон тарга гэх мэт.

Хамгийн түрүүнд ‘тос’ гэдэгтэй дүйцүүлэн авч үзэх монгол хэлний ‘торго’, ‘сүү’, ‘өөх’ зэрэг үг багтаж байна. Монгол хэлэнд эерэг сайн сайхан утга илтгэдэг тостой эн тэнцүү жишиг хэмжүүр болгож авч үздэг зүйлийн нэг бол ‘торго’ гэдэг үг байна.

Тос торго, тос өөх, тос сүү зэргийг хослуулан хэрэглэж эерэг утга илэрхийлэх жишээ баримт олон байна. Тухайлбал, монгол хэлний

тос идэж, торго өмсөж явах ≈ идэх хоолтой, өмсөх хувцастай сайн сайхан амьдрах;

тос идэх хишиггүй, торго өмсөх буянгүй ≈ амьдрал тааруу, өлөн зөлмөн ядуу гуцуу амьдрах;

тос идээд мах суухгүй, торго өмсөөд өнгө орохгүй ≈ хэдий сайныг идэж, сайхныг эдлэвч өөдөлж дэвжихгүй, урагшгүй байх;

торгон дотор хөрвөөх, тосон дотор умбах ≈ аз жаргалтай, сайн сайхан байх;

тос уух газраасаа, торго өмсөх биенээсээ ≈ аливаа хүний сайн сайхан амьдрах нь зөвхөн өөрөөс нь шалтгаалдаг;

тос шиг тарган, торго шиг зөөлөн ≈ чанартай, тансаг зөөлөн;

торгон дээлтэй, тосон идээтэй ≈ амьдрал сайн, идээ ундаа элбэг дэлбэг;

торго өмсөвч сүүдэр нь хар, тос уувч баас нь өмхий ≈ хэдий сайн сайхан явах боломж байвч арчаагүй, хэдий хоол унд сайн боловч ажилгүй;

тосон дээр тоглох, өөхөн дээр бөмбөрөх ≈ аз жаргалтай байх гэх мэт зүйр цэцэн үгэнд тарган цатгалан хоолтой ундтай байдал, торго өмссөн аз жаргалтай баян тарган байдал, орчин үеийн хэллэгээр бол амьдралын чанар сайн гэсэн нэг тал, хэдий ийм тавилан заяа тохиовч өөрийн ажилгүй, арчгүй байдлаас болж тэр хувь заяа үл биелэх хэмээх хоёр эсрэг тэсрэг байдлыг эн тэнцүү авч үзсэн байна.

Одоо эсрэгцэх харьцаа илэрхийлэх ойлголтыг авч үзье. Монгол хэлний “*Сайн гэрч уруулдаа тостой, муу гэрч бөгсөндөө ташууртай.*” хэмээх хэвшмэл хэлц нь аливаа сайн зүйл хийвэл шагнал урамшилтай, харин муу зүйл хийвэл зэм шийтгэлтэй гэх утга илтгэх юм. Энд буй ‘тос’ хэмээх үг нь хоол унд ч юм уу аливаа шан харамжийг, ‘ташуур’ хэмээх үг нь зодуур, цохиур, шийтгэлийг төлөөлөх юм. Үүнтэй төстэй загвар бүхий нэг хэвшмэл хэлц бол “*Ажилч хүн тос идэх, арилжаач хүн хараал идэх*” гэх хэлц юм. Энэ нь ажилсаг хөдөлмөрч байвал хоолтой ундтай, амьдралтай байх, харин арилжаа наймаа хийдэг хүн бол байнга янз бүрийн хүнтэй

харилцаж байдаг учраас хэл ам, хэрүүл тэмцэл арилахгүй байнга хэрүүл хараал хүртэж байдаг гэсэн шиг сөрөг утга илтгэх юм. Энэ бол хоёр өөр зүйлийн эцсийн үр дүнг илтгэсэн утга үүсгэж байгаагаараа дээрхтэй адил байна.

Эсрэгцэх харьцааны тухай авч үзэхэд эсрэг утгатай үгийг заавал анзаарах ёстой. Монгол хэлний эсрэг утгатай үгийн утга зүйг судалсан доктор Р.Батаахүү эсрэг үг болон утгыг “1-рт нэрлэгдэж буй юм, үзэгдэл, үйл явц, 2-рт үгээр илрэх утга, ухагдахуун, 3-рт бусад үгтэйгээ холбогдох харьцаанд эсрэг утгыг авч үзсэн ба авианы чанга сул, уужим уйтнаас авхуулаад өгүүлбэрт хүртэл эсрэг утга санаа байх төдийгүй, эсрэгцэх чанар нь байгаль, нийгэм, сэтгэхүйн бүх үзэгдэлд адил байдаг өргөн ухагдахуун” (1988: 105) гэж үзжээ.

Монгол хэлний хувьд ‘тос’ гэдэг үгтэй хамгийн түгээмэл эсрэгцэл бүхий үг нь ‘ус’ юм. Монгол хэлний толь бичгүүдэд ‘тос’-ыг ‘ус’-тай эсрэгцүүлэн үзүүлснийг зөвхөн ойролцоо, эсрэг утгат үгийн толь бичигт тодорхой жишээтэй оруулсан байна (Бат-Ирээдүй, 2019: 269) Харин бидний цуглуулсан жишээ нь бүгд хэвшмэл хэлц байх бөгөөд хэлцэжсэн утга илэрхийлнэ. Тухайлбал, “*Ажил хийсэн нь амандаа тостой, ажилгүй суусан нь амандаа устай*” гэвэл ажил хийсэн хүний амьдрал сайн, хоолтой ундтай, ажилгүй залхуурч суух хүн хар уснаас өөр идэж уух юмгүй, муу амьдралтай гэх утга, “*Ус хөлддөг, тос царцдаг*” гэвэл ус, тосны физик чанарын үндсэн дээр аливаа сайн мууг буюу усны муу, тосны сайн чанартай болохыг, “*Усыг тосоор, ачийг бачаар*” гэвэл муу юмны хариуд сайн юм, сайн юмны хариуд муу юм ч байж болох санааг, “*Тоглоом толгойд харш, тос усанд харш.*” гэвэл тоглоом наадам амьдралд харш, тос усанд харш болохыг, “*Сайн санаатны үг нь тос, муу санаатны үг нь ус*”, “*Сайныг шахвал тос гарна, мууг шахвал ус гарна*” гэвэл сайн санааны үр дүн сайн, муу сэтгэл муу үйлийн үр дүн устай адил муу; “*Тос усанд шингэхгүй.*” гэвэл ус тос хэзээ ч нийлж нэгдэхгүй физик чанарт үндэслэсэн сайн муу хоёр хэзээ ч эвлэрч нийлэхгүй гэх утга, “*Тустай хүн тос адил, Тусгүй хүн ус адил.*” гэвэл мөн тусч чанар сайн, тусгүй хүн ус адил муу гэх утга илэрхийлж байна.

Монгол хэлний “*Ууртай хүнээр ус зөөлгө, ухаантай хүнээр тос зөөлгө.*” гэх нэг хэвшмэл хэлц байдаг. Үүний утгыг тайлбарлуулахаар монгол хэлний мэргэжлийн багш нарт хандаж үзэхэд янз бүрээр тайлбарлаж байлаа. Энэ бол хүн ууртай үедээ бодлогогүй, юу ч хийж магадгүй сайн мууг ялгадаггүй бөгөөд харин уур уцааргүй тайван ухаантай байх үедээ аливаа сайн мууг ялгадаг, сайн зүйлийг үнэлдэг гэх утга илтгэх юм.

Мөн монгол хэлний “*Үнэн үг шар тос, худал үг хар ус.*” хэмээх хэлц нь худал үнэний дэнс, үнэ цэнийг тос ус лугаа харшуулан үзүүлсэн бөгөөд харин “*Хүний эрхээр тос уухаар өөрийн дураар ус уу.*” гэхээр аливаа хөндлөнгийн эрхшээлд байж жаргахаар өөрийн дураар дуртайгаа хийгээд явах нь дээр гэсэн шиг утга илэрхийлэх ажээ.

Монгол хэлний хэвшмэл хэллэгүүдийг ажиглавал ‘тос’ хэмээх үгийг үгийн сангийн хувьд хаа хамааралгүй тоос гэх үгтэй эсрэгцүүлсэн нь арвин бөгөөд сонин байна. Энэ нь нэг талаас монгол шүлгийн толгой холбох, ижилсүүлэх, нөгөө талаас авиа, дуудлага зүйн талаас ижилсүүлсэн байж болох тал нь илүү ойр боловч мал аж ахуй эрхэлдэг хүмүүсийн хувьд тоос бол тостой эсрэгцүүлж болох бас нэгэн өвөрмөц жишиг учраас монгол хүний сэтгэлгээнд тоосыг тостой эсрэгцүүлэн үзэж байх шиг байна. Тухайлбал,

Тос цохисон хүн гараа долоодог, тоос цохисон хүн гараа угаадаг.

Тоос нь гадагшаа, тос нь дотогшоо.

Тоос нь гаднаас, тос нь дотроос.

Тоосонд дарагдахаар тосонд дарагд.

Тосны дотор, тоосны гадар.

Тосыг дотроо, тоосыг гаднаа гэх мэт хувилбар олон байна.

Монголчуудын хувьд мөн ‘тос’-ны эсрэгцэх харьцаанд ‘цус’ байна. Гэхдээ үгийн сангийн хувьд ‘тос’, ‘цус’ гэх үгс нь харьцангуй хамааралгүй боловч соёлын ойлголтын хувьд сөрөг ойлголт, эсрэгцэх сэтгэхүйг бий болгож харшуулж байна. Тухайлбал,

Ажлын сайнаар ам тостой.

Аашны муугаар толгой цустай.

Хараалын үзүүрт цус, ерөөлийн үзүүрт тос.

*Айраг бүлбэл тос унадаг, авир сөрвөл цус унадаг,
Эвийн эцэст тос, эвдрэлийн эцэст цус* гэх буюу
Цусаа гартал зодолдох, тосоо гартал тэврэлдэх (хошин хэлц) гэх мэтээр эсрэгцүүлэн үзэж байна. ‘Тос’ гэх нэр үгийн хувьд ‘тосдох’ хэмээх үйл үгээр илэрсэн хэвшмэл хэлц цөөнгүй байдаг. Энэ нь мөн чанарын хувьд ‘тос’ гэдэг үгийг хэрэглэх агуулгатай агаар нэгэн болой. Жишээлбэл,
Ажил хийвэл ам тосдоно.
Адуу мал хариулбал ам тосдоно.
Мал тэжээвэл ам тосдоно. гэх мэт.

Зарим тохиолдолд ‘тос’ хэмээх үгийг хоршин хэрэглэсэн жишээ үзэгдэнэ. Тухайлбал, ‘тос’ хэмээх үгийг ‘өрөм’ гэдэг гэдэг үгтэй хоршин “*Өрөм тос малаас, өнгө зүс сэтгэлээс.*” хэмээн хэлж буй нь ‘тос’ хэмээх үгийн үндсэн утга буюу дээрх ‘өөх’-тэй адил эерэг утгаар хэрэглэгдэж байна.

5. Судалгааны үр дүн

Мэдээж, олон зуун жилийн нүүдлийн мал аж ахуйтан монголчуудын аливааг үнэлэх үнэлэмжийн туршлагыг ганц тостой эсрэгцэх харьцаагаар авч үзэж болохгүй нь тодорхой. Харин “Нэг тодорхой үндэстэн угсаатны тухайд тэдний уламжлалт оюуны соёлын мөн чанар нь тэдний сэтгэлгээний тогтвортой хэв шинж юм. Сэтгэлгээний тогтвортой хэв шинж нь юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг сайн муу, сайхан муухай, хэрэгтэй хэрэггүй, таатай таагүй, хүсүүштэй хүсэшгүй, жирийн жигтэй гэх зэрэг эсрэгцсэн айд харгалзуулан үнэлж хэвшүүлсэн дадхал зуршил гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл үнэлэмж (value) бол үндэстний сэтгэлгээний онцлогийг тодорхойлох хамгийн гол шинж, үндсэн шалгуур юм. Үнэлэмжийг үүсгэхдээ янз бүрийн жишиг хэмжүүр (эталон)-ийг тогтоон ашигласан байдаг” (Баянсан, 2016: 37).

Монголчуудын үндэсний сэтгэлгээний онцлогийг судлахын тулд тэдний үеийн үед бүтээсэн тогтвортой хэллэгийг маш олон талаас нь нарийн ажиглах ёстой. Монголчуудын сэтгэлгээний байдлыг судлахдаа монгол хүн юуг юутай эерэг буюу дүйцүүлэх, юуг юутай сөрөг буюу эсрэгцүүлэх хандлагаар үзэж байна вэ гэдгийг нарийн анхаарч чадвал тэдний өөр бусад үндэстнээс ялгарах сэтгэлгээний бас нэгэн онцлогийг гаргаж болох боломжтой юм шиг санагдана. Учир нь профессор Ж.Баянсан нар “сэтгэлгээ бол үндэсний шинжтэй, харин сэтгэхүй бол нийт хүн төрөлхтний шинжтэй зүйл гэж ялган ойлгож болно” (2016: 39) гэж үзсэн бөгөөд монгол хүний сэтгэлгээний онцлог бол юуг юутай эсрэгцүүлж үзэж байгаа нь бусад үндэстнээс ялгарах бас нэгэн сонирхолтой тал болох юм.

Бид энэ удаа ‘тос’ хэмээх энэ үгийн эсрэгцлийн тухай судлах зорилго тавьж, монгол ардын аман зохиолын зүйлд энэ нь ямар ямар үгтэй агуулгаараа эсрэгцэх утга илэрхийлж байгааг шүүрдэн үзэж, өөрсдийн саналыг дэвшүүллээ.

6. Дүгнэлт

Хэл бол соёл. Аливаа үндэстний олон зуун жилийн турш бий болгосон сүегэр нэгж бол соёлын бэлгэ тэмдэг учраас түүнээс маш их зүйлийг мэдэж таньж болно. Дээрх жишээнүүдээс үзвэл эсрэг утгын бинарын онол буюу хос ёсны онол, зүйрлэлийн ухагдахууны үзэл санааны үндсэн дээр хэлний эсрэгцэх харьцаа нь зөвхөн семантик буюу бүтцийн асуудал төдий биш соёлын танин мэдэхүй, амьдралын туршлага, бэлгэдэл зэрэг олон зүйлийг тусгасан эсрэг тэсрэг буюу эсрэгцэх чанар байдаг юм гэдгийг батлах явдал болно. Өөрөөр хэлбэл монголчуудын сэтгэлгээн дэх тос хэмээх ойлголт бол зөвхөн хоол ундны нэгэн чухал төрөл, хэрэгцээт хүнс биш соёлын тэмдэг, ажил амьдралын үнэ цэн хэмээх гүн ухааны утга, эцсийн үр дүнгийн утгыг тээгч тэмдэг болж байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл зөвхөн монгол сэтгэлгээтэй хүний хувьд жишээлбэл, тос ус, тос цус, тос хараал нь эсрэгцэх харьцаа заах ойлголт байж болдог юм байна гэдгийг дээрх жишээ баримтаас харж болно. Эндээс ‘тос’ хэмээх бодисын физик шинж

чанарыг алгасаж, тухайн үгийн бэлгэ тэмдгийн шинж чанар хүртэлх монголчуудын диалектик сэтгэлгээний хэв маягийн онцлогийг харж болно. Эдгээр товч бөгөөд тодорхой, далд санаа, гүн утга бүхий зүйр цэцэн үгс нь нүүдэлчдийн амьдралын олон зуун жилийн туршлагаар дамжин батлагдсан мэргэн ухаан бөгөөд улам удаан жил оршин тогтнох хэл соёлыг хадгалан дамжуулах ард түмний өөрийнх нь бүтээсэн бүтээл юм. Ийнхүү цаашид хэл шинжлэлийн үүднээс монгол зүйр цэцэн үг, хэвшмэл хэллэг, сүегэр нэгжийн эсрэгцэх чанар буюу антоним чанарын харилцан хамаарлыг харьцуулан үзэх нь утга санаа, үнэт зүйлийг судлах, монголчуудын ертөнцийг үзэх үзлийг судлах үүднээс эрдэм шинжилгээний болон хэрэглээний чухал ач холбогдолтой юм.

Ном зүй

А. Монгол хэлээр:

- Батаахүү, Р.** (1987). *Монгол хэлний эсрэг үгийн зарим онцлог*. Улаанбаатар. [Bataahuu, R. *Mongol khelnii esreg ügiin zarim ontslog* [Some features of Mongolian antonyms]. Ulaanbaatar. 1987.]
- Бат-Ирээдүй, Ж.** (2014). *Монгол хэлний хэлц үг, хэллэгийн утга хэрэглээ*. Улаанбаатар. [Bat-Ireedui, J. *Mongol khelnii khelts üg, khellegiin utga khereglee* Meaning and Usage of Mongolian Idioms]. Ulaanbaatar. 2014.]
- Бат-Ирээдүй, Ж нар.** (2007). *Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат хэлц үгийн сан*. Улаанбаатар. [Bat-Ireedui, J. *Mongol khelnii oiroltsoo, esreg utgat khelts ügiin san* [Dictionary of Mongolian idiomatic sonynyms and antonyms]. Ulaanbaatar. 2007.]
- Бат-Ирээдүй, Ж.** (2019). *Монгол хэлний дүймэн: Ойролцоо утгат үгийн толь бичиг*. Улаанбаатар. [Bat-Ireedui, J. *Mongol khelnii düimen: Oiroltsoo utgat ügiin toli bichig* [Mongolian Thesaurus: Dictionary of Mongolian Synonyms]. Ulaanbaatar. 2019.]
- Баянсан, Ж.** (2016). *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Улаанбаатар. [Bayansan, J. *Soyol, khel, ündestnii setgelgee* [Culture, Language and Nationality]. Ulaanbaatar. 2016.]
- Гэрэлмаа, Г.** (2019). Монгол хэлний ‘тос’ хэмээх үгийн танихуйн утга. *Монгол судлалын чуулган*. №26(61), 95-98. [Gerelmaa, G. Meaning of the Mongolian word ‘tos’. *Mongol sudlалын чуулган*. Ulaanbaatar:2019. №26(61), 95-98.]
- Заяабаатар, Д.** (1999). *Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж*. Улаанбаатар. [Zayabaatar. D, *Mongol zuir tsetsen ügiin gurban myangan deej* [Best 3000 proverbs of Mongolian]. Ulaanbaatar. 1999.]

Б. Гадаад хэлээр:

- Charles W.Kreidler** (2014). *Introducing English Semantics*, London. <https://doi.org/10.4324/9781315886428>